ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 19 өдөр Дугаар 13/09 Өвт

Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн дүн, 2020 оны үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2."а", Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бат-Өлзий сумын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 96.7 хувьтай "Үр дүнтэй" гэж дүгнэсүгэй.

2. Бат-Өлзий сумын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Сумын эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хагас бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга (М.Жамъяншарав)-т даалгасугай.

ДАРГА Д.ЦЭРЭНТОГТОХ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны
12 дугаар сарын 19-ний өдрийн 13/09 дугаар тогтоолын хавсралт

## БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **1.1. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | |
| ***Зорилт 1. Экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, бохирдол хомсдол бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 1 | СЗДҮАХ 1.1.5 | Аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон жуулчдын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын замын маршрутын дагуух дэд бүтэц, зам гүүрийн нөхцөлийг сайжруулна. | Аялал жуулчлал эрхлэгчдийн тоогоор | Аялал жуулчлалын зам дагуух дэд бүтэц, зам, гүүрийн нөхцөл сайжирсан байна. | Хувийн хөрөнгө оруулалт | |
| 2 | СЗДҮАХ 1.4.2 | Сумын халуун рашааныг түшиглэн жуулчлалд зориулсан эмнэлэг, амралт, ардын уламжлалт эмчилгээ, үйлчилгээний газруудыг бодлогоор дэмжиж, хөгжүүлэх | 1 | Халуун рашааныг ашиглан эдийн засгийн эргэлтэнд оруулсан байна. | Хувийн хөрөнгө оруулалт | |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| ***Зорилт 1. Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулж, төсвийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар үр өгөөжийг нь дээшлүүлэх, байгалийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар сумын эдийн засгийг тэлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ.*** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | АЗДҮАХ 2.6.3 | Орон нутгийн татварын баазыг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг урьд оны түвшингээс бууруулахгүй байх | Улс,аймаг, сумын татварын орлогын нэр төрлөөр биелэлтийг хангах | Татварын орлогыг сар бүр төлөвлөгөөний дагуу биелүүлсэн байх. | Орон нутгийн төсөв | Татварын улсын байцаагч Санхүүгийн алба |
| 4 | | Төсвийн ил тод байдлыг ханган орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг хагас бүтэн жилээр ИТХуралд тайлагнах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | 100% | = | Санхүүгийн алба |
| 5 | СЗДҮАХ 1.1.2 | Засаг даргын үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хагас жилээр, гүйцэтгэлийг бүтэн жилээр тайлагнана. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | 100% | = | Санхүүгийн алба |
| **Хөдөө аж ахуй** | | | | | | |
| 6 | СЗДҮАХ 1.3.1 | Фермерийн аж ахуйг дэмжиж, мах, сүүний чиглэлийн малыг өсгөхөд дэмжлэг үзүүлэх | ААН, иргэдийн тоогоор | Сүүний үйлдвэртэй хамтран ажиллах нөхцөл боломж сайжирна. | Сум хөгжүүлэх сан | ХАА тасаг |
| 7 | | Өвс, тэжээлийн агуулах, саравч шинээр барих | үйл ажиллагааны хэрэгжилтээр | Өвс тэжээл нөөцлөх боломж бүрдэнэ. | Төсөл хөтөлбөр ОНТөсөв | ЗДТГазар |
| 8 | СЗДҮАХ 1.4.4 | 1 дүгээр багийн Горхин дэнж , 3 дугаар багийн Рамын дэнж, 4 дүгээр багийн төвд худаг гаргах. | Ажлын гүйцэтгэлээр | Хүн, малын ундны усны хангамж сайжирна. | Төсөл хөтөлбөр | |
| 9 | СЗДҮАХ 1.3.2 | Баригдсан худаг дээр нарны сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж байрлуулах | Ажлын гүйцэтгэлээр | | Төсөл хөтөлбөр<br>ОНТөсөв | |
| 10 | СЗДҮАХ 1.3.3 | Нэг сум нэгдсэн мал эмнэлэг" хөтөлбөрийн | | Мал эмнэлгийн барилгатай болно | Төсөл хөтөлбөр | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хүрээнд мал эмнэлгийн барилга барих. | | | | |
| 11 | АЗДҮАХ 2.4.4.4 | Залуу малчдыг бэлтгэх ажлын хүрээнд Өвөрмонголд туршлага судлуулах. | Малчдын тоогоор | Малчид гадаадын туршлагаас суралцсан байна. | Орон нутгийн төсөв, хөтөлбөр | |
| 12 | СЗДҮАХ 1.3.2 | Хүйтэн булгийн эхийг хаших | 1 | Булгийн эх орчны бохирдлоос хамгаалагдана | ОНХСан | |
| 13 | СЗДҮАХ 1.3.7 | Мал угаалгын ваннтай болох. | | Малын эрүүл мэнд | ОНТөсөв | |
| **1.2: ДЭД БҮТЭЦ** | | | | | | |
| Зорилт 1: Орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх, засвахлах, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ. | | | | | | |
| 14 | СЗДҮАХ 1.2.2 | Орхон гол болон Цагаан голын төмөр бетонон гүүрийг ашиглалтанд бүрэн оруулж, хоорондох 7.2 км сайжруулсан замыг ашиглалтанд бүрэн оруулна. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | Орхон, Цагаан гол, Могойтын голууд бетонон гүүртэй болно. | Улсынтөсөв | Засаг дарга ЗДТГазар |
| 15 | СЗДҮАХ 1.2.2 | Могойтын голын 30.4 м төмөр бетонон гүүр, Цагаан голын гүүр хоорондох 1.3 км замыг ашиглалтанд бүрэн оруулна. | Ажлын гүйцэтгэлээр | Замыг сайжруулан зассан байна. | Улсын төсөв | |
| 16 | СЗДҮАХ 1.2.2 | Улаан голын гүүрийг шинээр барьж ашиглалтанд оруулна. | | Улааны гол гүүртэй болсон байна. | ОНХСан | |
| 17 | СЗДҮАХ 1.2.5 | Бүрэгтий багийн төвийн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу, ахмад, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Бүрэгтий баг үйлчилгээний төвтэй болсон байна. | ОНТөсөв ОНХСан | ЗДТГазар Багийн захиргаа |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зориулсан соёл үйлчилгээний төв шинээр барих | | | | |
| 18 | СЗДҮАХ 1.4.6 | Хогийн хуучин цэгийг Ландфиллийн аргаар бүрэн булшилж, орчны хогийг бүрэн цэвэрлэж хүлээлгэн авна. | Ажлын гүйцэтгэлээр | Хогийн цэг бүрэн цэвэрлэгдсэн байна. | ОНХСан | ЗДТГазар |
| 19 | АЗДҮАХ 2.5.2.9 | Өвтийн Мухар хустад цаны баaз барих газар сумын төвөөс цахилгаан дамжуулах агаарын шугам татах | Ажлын гүйцэтгэлээр | Цагаан хангамжаар хангагдана. | Улс, орон нутгийн төсөв | |
| 20 | | Сумын төвийн 6,2 км замын ажлыг зураг төсвийн дагуу бүрэн хийлгэж хүлээн авна. | Үйл ажиллагааны хэрэгилтээр | Сумын төвийн тохижилт сайжирсан байна. | Улсын төсөв | |
| 21 | | 2 дугаар багийн Хүрэмний зам засах | Ажлын гүйцэтгэлээр | Хүрэмний зам засагдаж, багийн иргэдийн зорчих нөхцөл сайжирна | ОНХСан | |
| 22 | СЗДҮАХ 1.4.6 | 3, 5 дугаар багт хогийн машинтай болох. | Хогийн машинтай болсон байна. | Хогний менежент сайжирна. | ОНХСан | ЗДТГазар Багийн захиргаа |
| ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТУУД | | | | | | |
| ***Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.*** | | | | | | |
| **Эрүүл мэнд** | | | | | | |
| 23 | СЗДҮАХ 2.1.1 | Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг бүрдүүлж, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх | үйл ажиллаганы хэрэгжилтээр | Залуу эмч нар ажлын дадлага туршлагатай болсон байна. | ОНТөсөв | ЭМТөв |
| 24 | АЗДҮАХ 3.1.4 | ЭМТөвийн гематологийн аппараттай болгоно | Үйлчилгээний багцын хэрэгжилтээр | Лабораторийн шинжилгээ хийх чадавх сайжирсан | ОНТөсөв | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | | |
| 25 | АЗДҮАХ 3.5 | Эмч нарын орон сууцны барилгад засвар хийх | 1 барилга | Эмч нарын ажиллан нөхцөл сайжирсан байна | Улс, ОНТөсөв | ЭМТөв |
| **Боловсрол** | | | | | | |
| 26 | СЗДҮАХ 2.2.3 | 1 дүгээр Цэцэрлэгийн барилгад их засвар хийх | Ажлын гүйцэтгэлээр | Суралцах орчин сайжирсан байна. | Улсын төсөв | |
| 27 | СЗДҮАХ | 100 хүүхдийн дотуур байранд их засвар хийх | Ажлын гүйцэтгэлээр | Дотуур байранд суралцагчдын орчин сайжирсан байна. | Улсын төсөв | ЕБСургууль |
| 28 | | ЕБС-ийн харъяа хөл бөмбөгийн талбайтай болох | 1 | Стандартын хөл бөмбөгийн талбай, биеийн тамирын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байна. | Улс, орон нутгийн төсөв | |
| Төрийн үйлчилгээ | | | | | | |
| ***Зорилт 1. Төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй хариуцлага алдаж, ёс зүйн алдаа гаргасан төрийн албан хаагчдад хууль журмын дагуу хариуцлага тооцож, төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*** | | | | | | |
| 29 | АЗДҮАХ 4.4.2 | Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийг ажлын бүтээмж, иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанартай уялдуулж олгодог зарчим нэвтрүүлэх | Ажиллагсдын тоогоор | Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сайжирсан байна | ОНТөсөв | ЗДТГазар Төсөвт байгууллагууд |
| 30 | | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулах | Иргэдийн тоогоор | Иргэдэд төрийн үйлчилгээг чанартай, ил тод хүргэсэн байна. | | ЗДТГазар |

Нийт 30 ажил үйлчилгээ